

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ТҮҮХИЙН ҮЕЧЛЭЛИЙН АСУУДАЛД

МУИС, ОУХС-ийн багш

З.Энхтайван

Олон улсын эрх зүй нь анхлан нийгмийн хөгжлийн үр дүнд бий болсон бөгөөд хүй нэгдлийн үеийн овог, аймгууд хоорондын харилцаагаар бичигдээгүй хуулиар зохицуулагдаж ирснийг түүхийн үйл явц харуулж байна. Олон улсын эрх зүй үүсэхийн үндэс нь нийгэм төр улсад хуваагдаж, тэдгээр улсууд хоорондоо хэлхээ холбоо тогтоох шаардлагаас үүдэлтэй.

Олон улсын эрх зүйн түүх нь олон улсын харилцааны түүх, хүн төрөлхтний соёл иргэншлийн түүх, тухайлбал, түүний үүссэн төвүүдтэй нягт холбоотой. Энд эртний Хятад, Энэтхэг, Нил, Тигр, Евфрат голын хөндий болон Эртний Герэг, Ромыг дурдаж болно. Дээрх төвүүдэд бий болсон төр улсууд хоорондоо олон талт харилцаа тогтоож, олон улсын эрх зүйн хэм хэмжээ үүсэхэд түлхэц өгсөн. Олон улсын эрх зүйн түүхийн үечлэлийн асуудал нь хамгийн маргаантай бөгөөд ээдрээтэйд тооцогддог нь бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хэмжүүр байдаггүйтэй холбоотой. Хэдийгээр олон улсын эрх зүйн түүхийн үечлэл нь олон улсын харилцааны түүхийн үечлэлтэй холбоотой ч олон улсын эрх зүйн хэм хэмжээний үүсэл, хөгжил, бүрэлдэн тогтох үйл явц нь түүхийн эргэлтийн үеүүдтэй салшгүй холбоотой байдаг.

Олон улсын эрх зүйн түүхийг судалсан ихэнх бүтээлд түүнийг төр, улсуудын бүрэлдэн тогтсон хийгээд цаашдын хөгжилтэй холбон үзэж байв. Өөр өөр бүс нутгуудын төр улсуудын хөгжлийн нийтлэг зүйл нь олон улсын эрх зүйн ижил төстэй хэм хэмжээ бүрэлдэн тогтоход нөлөөлсөн. Олон улсын эрх зүйн түүхийг 1990-ээд оноос өмнө Зөвлөлтийн хуулийн шинжлэх ухаанд түүхийг марксист-ленинист сургаалийн үүднээс үечилж ирсэн. Олон улсын эрх зүйн түүхийг өрнөдийн зарим онолчид Вестфалийн гэрээ /1648/ хийгээд Гуго Гроцийн бүтээлүүд /17 дугаар зууны эхэн үе/ нийтлэгдсэнтэй холбон үздэг. Энд мөн Л.Оппенгейм, Ч.Хайд нарыг дурдаж болно. Түүнчлэн олон улсын хуульч, эрдэмтэн М.Фошиль, Н.А.Бекяшев, Ю.М.Колосов нар олон улсын эрх зүйн түүхийн үечлэлийг янз бүрийн аргачлалаар авч үзэн онолын үндэслэлээ толилуулж ирснээр Москвагийн Хууль Зүйн Академийн эрдэмтэн багш Г.Стародубцевийн үечлэлийг баримтлах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Олон улсын эрх зүй эрт дээр үед МЭӨ 4 мянганаас МЭ 476 он хүртэл /Боолын нийгэм, эдийн засгийн формаци/;
2. Олон улсын эрх зүй дундад зуунд - МЭ 476-1648 он /Феодализмын нийгэм, эдийн засгийн формаци/;
3. Олон улсын эрх зүйн сонгодог үе 1648 - 1917 он /Капитализмын нийгэм, эдийн засгийн формаци/;

4. Олон улсын эрх зүй XX зуунд /1917 - XX зууны эцэс/.

Олон улсын эрх зүйн түүх бол нийгмийн түүхийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг билээ. Иймд олон улсын эрх зүйн түүхийн үечлэлийг хүн төрөлхтний нийгэм, эдийн засгийн формацитай холбоотойгоор авч үзэж дээрх 4 үед хуваасан болно.

1. Олон Улсын Эрх Зүй эрт дээр үед

МЭӨ 4 мянган оноос МЭ 476 он хүртэл бүрэлдэн тогтсон эрх зүйн зарчим, хэм хэмжээний тогтолцоог Эртний үеийн олон улсын эрх зүй гэнэ. Энэ үеийн онцлог шинж нь:

1. Овог аймгуудын хооронд баримталж байсан горим, журмыг заншил, гэрээнд бататгасан;

2. Шашныг тахиж шүтэх явдал үүсэж хөгжсөн;

3. Бүс нутгийн онцлогийг харгалзсан;

4. ОУЭЗ-н үндсэн эх сурвалж нь заншил байсан.

Түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэснээр анхны төр улсууд МЭӨ 4 мянган жилийн эцэс 3 мянган жилийн эхэнд буй болжээ. Энэ үед анхны төр улсууд хоорондоо ямар нэгэн харилцаанд орж байснаас олон улсын харилцааны анхны хэлбэр үүссэн гэж хэлж болно. Бидэнд өвлөгдөж ирсэн түүхийн эх сурвалж, дурсгалуудад тэр үеийн улс орнууд доорхи асуудлаар гэрээ хэлэлцээр хийж байсан байна. Үүнд: дайн зарлах, дуусгах, холбоотон болох зэргийг дурьдаж болно. Гэрээ хэлэлцээр хийхийн тулд элч төлөөлөгчдийг илгээдэг байв. Эрт дээр үеийн олон улсын эрх зүйн хөгжилд дайн үлэмж нөлөөлж байсныг дурьдах нь зүйтэй.

Улс орнууд харилцаагаа зохицуулахын тулд эхэн үед аман гэрээ хэлцэл хийдэг байсан бол бичиг үсэг үүссэнээр бичгийн хэлбэрээр хийгддэг болсон. Үүнд МЭӨ 2100 /3100/ онд Өмнөд Месопотамийн улс хот Лагаш, Умма хоёрын хооронд хил хязгаарын талаар байгуулсан гэрээг дурьдаж болно. Сонирхолтой нь дээрх гэрээг чулуун хавтан дээр сийлсэн бөгөөд түүний хэрэгжих баталгаа нь бурхан гэж байв. Түүнчлэн МЭӨ 1296 онд Египетийн Фараон Размес II Хеттийн хаан Хаттушил II хооронд байгуулсан цэргийн холбооны талаархи гэрээг дурьдаж болно. Үүнд хэлэлцэн тохиролцсон хоёр талын нутаг дэвсгэрт дайсан довтолбоос нэг нэгэндээ цэргийн туслалцаа үзүүлэх, бослого, үймээн самуун гарвал нэгэн адил дэмжлэг үзүүлж, урвагчдыг эд хогшилтой нь эгүүлж өгөх тухай заалт байсан. Гэрээ хэлэлцээрийн баталгаа нь Египетийн хийгээд Хеттийн эрэгтэй, эмэгтэй бурхад байлаа.

МЭӨ I мянганд Ойрхи дорнодын ОУХ-нд Ассири, Вавилон, Перс, Урарту улс чухал үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд дайн дажин, нутаг дэвсгэр булаан авах, алба татвар авах, цэргийн холбоо тогтоох, удам угсаа залгасан хаанчлалыг бэхжүүлэх талаар түлхүү анхаарч байлаа.

Энэ мянганд /МЭӨ 1 мянганд/ эртний Хятад, Энэтхэгт анхны төр улс буй болж байнгын дипломат хэлхээ холбоо тогтоон, олон улсын гэрээ хэлэлцээр байгуулдаг байв. Олон улсын асуудлуудыг шийдэхийн тулд эзэн

хаад чуулдаг байсан. Эртний Энэтхэгийн улсууд элчингүүдийн бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрч гэрээ хэлэлцээрийг энхийн болон дайны цагт байгуулсан гэж заагладаг байв. Дайн явуулах журамд онцгой ач холбогдол өгдөг байсан. Тухайлбал, дайныг шударга, шударга бус гэж хувааж хортой зэвсэг хэрэглэх, хүүхэд, хөгшчүүд, олзлогсод, эмэгтэйчүүдийг алахыг цээрлэж, шархдагсдыг чөлөөлөхийг чухалчилж байв.

МЭӨ 8 дугаар зуунд эртний Герегийн полис буюу хот-улсууд буй болж хоорондоо янз бүрийн хэлхээ холбоотой байлаа. Эхэн үедээ хот-улсын хоорондын харилцааг тусгай төлөөлөгч - элч буюу глашатай хэрэгжүүлдэг байснаа хожим нь элчин төлөөлөгчдийг илгээдэг болсон. Тэднийг элчин сайд тэргүүлж, тусгай эрх мэдлийн бэлгэ тэмдэг болсон нийлүүлсэн хоёр хавтас /диплом/ өргөн мэдүүлдэг байсан. Элч төлөөлөгчид бүрэн эрх эдэлж бурхдын ивээлд багтдаг байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Эртний Герегийн орнууд бусад орнуудтай гэрээ, хэлэлцээр хийхдээ энхийн гэрээ байгуулах, арбитражийн тухай, гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай зэрэг асуудлыг дэвшүүлдэг байсан. Эртний Герегийн хот-улсуудад гадаадын иргэдийн эрх ашгийг проксени /зочломтгой байдал/ институци хамгаалан зуучилж байсан. Зарим эрдэмтэд проксени нь орчин үеийн консулын институцийн үр хөврөлийг буй болгосон гэж үздэг.

Эртний Ром бусад орнуудтай харилцаагаа хөгжүүлэхдээ тусгай тайлгач бөө нарын тусламжтайгаар хэрэгжүүлэн дайн энхийн асуудал, олон улсын хэлэлцээр хийх, гадаад орнуудад гомдол гаргах асуудлыг авч хэлэлцдэг байлаа.

Ромчуудын өдөөсөн дайныг урьдчилан зарласан тохиолдолд шударгад тооцдог байв. Дайны үед ромчууд эзэлсэн хот суурин, оршин суугчид, эд баялагийг булаан эзэлж олзлогсдыг боол болгох буюу алж хяддаг байв.

Эртний Ромд, эртний Герегийн нэгэн адил эрх мэдэлгүй гадны иргэдийг ивээлдээ авч, тэдний асуудлыг хэлэлцэж эрх зүйн байдлыг нь тодорхойлох журам боловсруулсан. Үүний үр дүнд Эртний Ромд улс түмний эрхзүй (jus gentium) үүсэн буй болсон. Дундад зуунд Ромын эрх зүйг Европт нэвтрүүлэх үед jus gentium нь улс орнуудын шинжлэх ухаан, практикт "олон улсын эрх зүй" гэдэг ойлголт буй болгоход нөлөөлжээ.

Эртний Ром гадаадын орнуудтай хэлхээ холбоогоо өргөжүүлэхдээ элч төлөөлөгчдийг өргөнөөр ашиглаж байсан. Ромчууд гадны элч төлөөлөгчдийн бүрэн эрхт аюулгүй байдлыг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч байлаа. Үүнд дайтаж байсан орнуудын элч төлөөлөгчид ч мөн адил хамаардаг байв. Ромын эрх зүй олон улсын эрх зүйг цаашид хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлснийг эрдэмтэд тэмдэглэдэг.

Олон улсын эрх зүйн эх үүсвэрийг тавихад эртний монголчууд ч мөн багагүй хувь нэмэр оруулж ирсэн. МЭӨ 200 онд Хүннү улсын хаан Модун Шаньюй Хан улсын хаан Гао Ди-г Датун хотын орчим бүслэн байлдаж ялсны дараа МЭӨ 198 онд найрамдлын гэрээ байгуулсан.

Хүннүчүүд Хан улстай байгуулсан гэрээг чандлан сахиж зөрчсөн этгээдийг цээрлүүлэн шийтгэхээр тангараглан баталгаажуулж байжээ. Хүннүгийн үед гадны элч төлөөлөгчдийг найрсгаар хүлээн авч зочлон хамгаалах үүрэг бүхий "зочин эрхэлсэн түшмэл" байсан нь эртний Герегийн тусгай төлөөлөгч "проксени" –тэй утга, агуулга, үйл ажиллагаагаараа адил гэж болно. Хүннүгийн хаад гадаад улс оронд элч төлөөлөгч явуулахдаа алт, мөнгөн гэрэгэ / манжийн хааны үед пайз гэж нэрлэх болсон / шийтгэн олгож байжээ. Энэ нь Эртний Герегт элч төлөөлөгчидөө хэлэлцээ хийх эрх олгосноо нотлон "диплома" хэмээх хоёр давхарласан модон самбар олгодог байсантай төстэй зүйл байжээ. Дипломат гэдэг үг үүнээс үүдэлтэй гэж үздэг. Эртний монголчуудаас гадаад харилцаандаа баримталж байсан эдгээр хэв заншлыг Монголын дараа дараачийн хаад өвлөн авч үргэлжлүүлж байсан бөгөөд ялангуяа Чингис хааны үед тэдгээрийг улам нарийсган баяжуулжээ. Дайн тулалдааны үед сайн дураар бууж өгсөн улс, хотуудад өршөөл үзүүлж байхыг Чингисийн "Их засаг"-т хууль зүйн хэм хэмжээ болгон заасан байна.

2. Олон улсын эрх зүй дундад зуунд

V – XVII зуунд бүрэлдэн тогтсон эрх зүйн зарчим, хэм хэмжээний тогтолцоог дундад зууны олон улсын эрх зүй гэнэ. Энэ үеийн онцлог шинж нь:

1. Бүс нутгийн үзэл санаа
2. Заншлын хэм хэмжээ гэрээнийхээс давамгайлах
3. Олон улсын эрх зүйн хэм хэмжээ бүрэлдэх үйл явцад шашны нөлөө өсөн нэмэгдсэн явдал юм.

МЭ 476 онд Өрнөд Ромын эзэнт гүрэн задарч, түүний оронд Европын улс орнууд буй болсон. Анхны төр улсууд дээрх задралаас өмнө байгуулагдсаныг тэмдэглэх нь зүйтэй.

Европын улсуудын бүрэлдэн тогтох үйл явц IX зуунд дуусч, XVI – XVII зуунд үүссэн хязгааргүй эрхт хаант засаг буй болтол үргэлжилсэн феодалын тархай бутархай байдлаар солигдсон. Ромын эзэнт гүрний нутаг дэвсгэрт Европын улс орнуудаас гадна Ойрхи болон Дундад дорнодод Арабын Халифат буй болсон.

Хэдийгээр Дундад зууны үед улс орнууд байнгын дайн дажинтай байсан ч төр улсаа тохинуулах, олон улсын янз бүрийн харилцаанд орох шаардлагаас улбаалан /энд энхийн болон худалдааны харилцааг нэрлэж болно/ олон улсын эрх зүйн зарим нэгэн институци буй болоход нөлөөлсөн. Европ тивд Христийн сургаал нь оюун санааны хувьд улс орнуудыг нэгтгэж тэр үеийн хатуу ширүүн олон улсын харилцаанд зөөлрүүлэх нөлөө үзүүлж, эрх дураараа загнах явдлыг хязгаарлаж байлаа. Католик шашинтны чуулганаар шашны асуудлыг хэлэлцэхийн зэрэгцээ олон улсын эрх зүйд хамааралтай асуудлыг авч үздэг байлаа.

XIII зуунаас Италийн полис улс – хотуудад консулууд буй болж, гадаад орны нутаг дэвсгэрт амьдарч буй иргэдийнхээ эрх ашгийг

хамгаалах, үүсч буй болсон маргааныг шийдвэрлэхэд гол үүрэг гүйцэтгэж байлаа.

XV зуунд байнгын элчин сайдын яамд буй болж, элч төлөөлөгчдийн болон ЭСЯ-дын халдашгүй дархан байдлыг баталгаажуулсан.

XVI зуунаас Европын орнууд Туркээс эхлэн лалын шашны орнуудтай гэрээ хэлцэл байгуулж, дайнд бууж өгөх асуудлын журмыг боловсруулсан. Үүний мөн чанар нь зөвхөн Европын Христийг шүтэгчдэд шүүхийн салбар, татвар гувчуур төлөхөд хөнгөлөлт үзүүлэх явдал байлаа.

Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эрх эрчимтэй хөгжиж, зөвхөн дайн дуусгах, газар нутгийг бусдын эрх мэдэлд өгөх асуудлаар хязгаарлалгүй удам угсаа залгамжилсан хаант ёс, олон улсын улс төр, худалдааны харилцааг бэхжүүлэн хөгжүүлэх асуудал, олон улсын гэрээ хэлэлцээрийн биелэлтийг хангахад улс орнуудын онцгой анхаарлыг хандуулж байлаа, Үүнийг хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл нь христийн шашны хүндэтгэлийн тангараг байсан бөгөөд дараа нь Евангелийн судар болон загалмайг үнсдэг байв. Гэрээг зөрчигчдөд интердикт буюу Ромын пап ламаас шашны зан үйлийг явуулахыг хориглох шийтгэл оноодог байлаа. Хожим дээрх тангарагыг хангалтгүйд тооцон гурав дахь орны баталгаа /Энэ нь Ромын пап лам буюу Ариун Ромын эзэнт гүрний эзэн хаан гаргана/ гаргуулж, хүмүүсийг болон үнэт зүйлс, газар нутгийг барьцаанд авах болсон. Усан онгоц үйлдвэрлэх, далайн тээврийн хөгжил нь ОУХ болон Олон улсын эрх зүйг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байлаа. Дундад зуунд улс орнууд эрэг хавийнхаа усан хилийг эзэмшил газраа болгохыг эрмэлзэж байсан. Тухайлбал: Венец улс – Адриатын тэнгис, Генуя болон Пиза – Лигурийн тэнгис, Англи улс арлаа тойрсон тэнгисүүдийг г.м.

XV – XVI зууны газар зүйн агуу их нээлтүүд нь тэр үеийн далай тэнгисийн их гүрэн болох Испани, Португалийн санаархлыг өдөөн хатгаж байлаа. Үүнээс улбаалан цэргийн мөргөлдөөнийг даамжруулахгүйн тулд 1493 онд Ромын пап Александр VI Атлантын далайг Испани, Португалийн хооронд зааглаж, улмаар эдгээр орнууд 1494 болон 1529 онуудад Атлантын болон Номхон, Энэтхэгийн далайн сав газрын усан мандал, хуурай газрыг хуваах тухай гэрээ байгуулсан. Гэвч эдгээр санаархал нь бусад орнуудын хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан.

XVI зууны эцэс XVII зууны эхэнд Англи улмаар Нидерланд /Голланд/ нээлттэй тэнгисийн чөлөөт байдлын төлөө тэмцэж эхэлсэн. Олон улсын эрх зүйг үндэслэгч Голландын хуульч, философич Г.Гроций 1609 онд нийтлүүлсэн "Нээлттэй тэнгис" бүтээлдээ түүний чөлөөт байдлын зарчим газар нутагт хамаарах тэнгисийн усан мандал, өөрөөр хэлбэл, олон улсын эрх зүйд дэлхийн усан мандалтай холбоотой олон улсын харилцааны хэм хэмжээг зохицуулах эхийг тавьсан.

Дундад зуунд дайн дажин нь өдөр тутам ерийн үзэгдэл болж, түүний арга хэрэгслийг юугаар ч хязгаарладаггүй байжээ. Олзлогдсон эд хогшил, хөрөнгө, мөнгө ялагсдад оногдож, хот суурингууд балгас болж, хүүхэд эмэгтэйчүүд олзлогдод боолчлолын гашуун хувь заяаг

амсдаг байлаа. Дайн зарлахын өмнө улс орнууд дайтах болсон шалтгаанаа тайлбарлаж албан ёсоор зарласнаар шудрага дайнд тооцогддог байлаа.

Дундад зуунд олон улсын маргааныг энхийн арга, хэлбэр болох зуучлал – арбитрын шүүхээр шийдвэрлэх явдал өргөн хүрээтэй болж, арбитрын шүүхийн тухай тусгай гэрээ хэлэлцээр байгуулж байсан. Хэдийгээр энэ үед ОУЭЗ нь шинжлэх ухааны бие даасан салбар болоогүй ч зарим эрдэмтдийн бүтээлүүд анхаарал татаж байлаа. Үүнд 345 – 430 оны үед амьдарч байсан Августин Блаженный “Бурханы хотод” бүтээлдээ олон улсын гэрээ, хэлэлцээрийг чандлан мөрдөхийн чухлыг үндэслэж байсан бол, Фома Аквинский /1225-1275 он/ хүний байгалийн эрхийг бурханлиг эрхийн салшгүй бүрэлдэхүүн хэсэгт тооцож байсан нь ОУЭЗ-н цаашдын үзэл баримтлалд чухал нөлөө үзүүлсэн.

Энэ түүхэн үед ОУЭЗ-н үндсэн асуудлыг судалсан Гуго Гроцийн /1583-1654/ “Дайн ба энхийн тухай” 3 ном 1625 онд хэвлэгдсэн ба түүний үзэж байснаар ОУЭЗ нь улс орнуудын хэлэлцээр буюу заншилд тулгуурласан эрх гэж ойлгон үүний зэрэгцээ уг сурвалж нь байгаль дэлхий буюу бурхны хууль гэж тооцож байлаа. Өөрөөр хэлбэл, Г.Гроций байгалийн эрх болон позитив /эрэг/ эрхийг зааглаж байсан нь хууль зүйн шинжлэх ухаанд байгалийн болон позитив эрх гэсэн хоёр чиг хандлага үүсэхийн эхлэл болсон байна. Позитив /эрэг/ буюу хүсэл зоригоор үүссэн хэм хэмжээг Г.Гроций бурханлиг болон хүмүүнлиг гэж зааглаж байлаа. Байгалийн эрхийн гол төлөөлөгчид болох Самуэль Пуфендорф /1632-1694/, Барбейрак /1674-1744/ нар байгалийн эрхийн хэм хэмжээг феодалийн абсолютист дэглэмийн эсрэг сэргүүлэн тавихдаа хүний төрөлхийн мөн чанараас үүдэн байгалийн эрх үүсэх тухай үзэл санааг дэвшүүлсэн юм.

3. Олон Улсын Эрх Зүйн сонгодог үе

Вестфалийн гэрээнээс Версалийн гэрээ хүртэл 1648-1919 онуудад бүрэлдэн тогтсон эрх зүйн зарчим, хэм хэмжээний тогтолцоог олон улсын эрх зүйн сонгодог үе гэнэ. Энэ үеийн онцлог шинж нь:

1. Олон улсын эрх зүйн эх сурвалж нь гэрээ болсон,
2. Олон улсын эрх зүйн ардчиллын явц өргөжсөн,
3. Колоничлох бодлогын хэрэгжилт эрчимжсэн,
4. Улс хоорондын зөрчлийг шийдвэрлэх хууль ёсны арга бол дайн /хэдийгээр түүнийг буруутгах хандлага бүрэлдсэн ч/ болсон.

1618-1648 онуудад Европт шашны шалтгаанаас улбаатай үргэлжилсэн 30 жилийн дайны төгсгөлд байгуулсан Вестфалийн гэрээнд /1648-10-24/ Ариун Ромын гүрний эзэн хаан холбоотны хамт нөгөө талаас Швед, Франц холбоотны хамт гарын үсэг зурсан. Энэ гэрээ нь Европын орнуудын түүх, ОУЭЗ-н цаашдын хөгжилд чухал нөлөө үзүүлсэн. Үүнд анх удаа улс төрийн тэнцвэрт байдлын тогтолцоог тогтоож, гэрээний дагуу буй болсон Европын орнуудын нийтлэг нэгдэл нь тогтвортойд тооцогдож, гэрээг зөрчигсдийн эсрэг шудрага дайн

дэгдээхийг зөвшөөрсөн. Бүх улс орнууд тэнцүү эрхтэй болон газар нутгийн эрх, бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн. Гэхдээ германы улсууд нэг нэгнийхээ эрх ашигт харш гэрээ хэлэлцээр байгуулах эрхгүй байлаа.

Вестфалийн гэрээ нь гэрээгээ зөрчсөний хариуд дайн явуулахад хязгаарлал тогтоох заалт агуулж байлаа. Жишээ нь: 3 жилийн дотор маргаанаа энхийн аргаар буюу шүүхээр асуудал шийдвэрлүүлэх, дараа нь дайн зарлах гэх мэт.

Вестфалийн гэрээний гол ач холбогдол нь цаашид мөрдөн баримтлах ОУЭЗ-н сонгодог хэлбэрийн үндсийг буй болгосон.

ОУХ, ОУ-ын худалдаа өргөжин тэлсэн нь улс орнуудад консулын институци бэхжин тэдний эрх зүйн байдал, үүрэг зорилго нь ОУ-ын гэрээ, хэлэлцээрт тусгагдсанаар илэрч байсан.

XVI зуунд Испанийн хуульч Фле Витори Ромын эрх зүйд байсан "хүний эрх" хэмээх ойлголтоос гарал бүхий "үндэстнүүдийн эрх зүй" гэсэн нэр томъёог нэвтрүүлсэн бөгөөд хожим 1789 онд Английн гүн ухаантан Жереми Бентхам үүнийг өөрчлөн "Олон улсын эрх зүй" гэж нэрлэсэн байна.

Дундад зууны олон улсын эрх зүй нь ардчилсан зарчмаас ангид байсан бол 1789 оны Хүн ба Иргэний эрхийн Тунхаглал, 1791, 1793 оны Үндсэн хууль зэрэг Францын хувьсгалын баримт бичигт ард түмний бүрэн эрхт байдал, бусад улсын дотоод хэрэгт үл оролцох, улс гүрний нутаг дэвсгэрийн халдашгүй байдал зэрэг олон улсын эрх зүйн шинэ зарчмыг тунхагласан юм. Мөн АНУ анх бүрэлдэн тогтнох цагаасаа энх тайван, аюулгүй байдлыг дэлхийн түгээмэл байгууллагын тусламжтайгаар хангах, улс түмний өөртөө засан тохинох эрхийг хүндэтгэх, олон улсын харилцаанд эрх зүйн шударга ёсыг тогтоох, хүний эрхийг сахин хамгаалах зэрэг дэвшилт зарчмыг баримталж ирсэн байна.

Гэвч эдгээр ардчилсан зарчим олон улсын харилцаанд төлөвшин бэхжихэд багагүй хугацаа шаардагджээ. XX зууны эхийг хүртэл тэдгээрээс гажих, түүгээр ч барахгүй илэрхий зөрчих явдал хэвийн үзэгдэл байв. Ази, Африкийн орнуудад колонийн дэглэм тогтож, Ази, Африк, түүнчлэн Латин Америкт ардчилсан зарчмыг дэлгэрүүлэхгүй байсан.

Олон улсын харилцааны асуудлыг "соёлжсон" хэмээн нэрлэгдэж байсан Европын цөөн тооны том гүрэн шийдвэрлэж байсан. Тэр үеийн олон улсын эрх зүй зөвхөн эдгээр улсын хоорондын харилцааг зохицуулахаас биш "бүдүүлэг" гэгдэж байсан улс гүрнүүдэд холбогдолгүй гэж үзэж байв. Энэ үед улс гүрний дайтах эрх хууль ёсны гэж үзэж байсан ч ёс суртахууны хувьд буруутгаж байв.

4. Олон Улсын Эрх Зүй ХХ зуунд

Версалийн гэрээнээс хойш /1919/ бүрэлдэн тогтсон эрх зүйн зарчим, хэм хэмжээний тогтолцоог ХХ зууны олон улсын эрх зүй гэнэ. Энэ үеийн онцлог шинж нь:

1. Дайны эсрэг чиглэсэн,
2. Колонийн дарлалыг эсэргүүцсэн,
3. Гэрээний хэм, хэмжээний тооны өсөлт. Олон улсын эрх зүйн хуучин салбаруудын хөгжил /олон улсын эрх зүйн субъектууд, олон улсын эрх зүйн хариуцлага, хүний эрх/,
4. Шинжлэх ухаан, техникийн хувьсгалын үр дүнд шинэ салбар буй болсон /олон улсын аюулгүй байдлын эрх зүй, хүрээлэн буй орчны эрх зүй/,
5. Олон улсын эрх зүйн үйлчлэх орон зай эрс өргөжсөн /дэлхийн бөмбөрцөг, хуурай газар, газрын хэвлий, агаарын болон сансрын орон зай г.м./.

1919 Үндэстнүүдийн Холбоо /Лига Наций/ байгуулагдсанаар түүхэнд анх удаа олон улсын энх тайвныг сахин хамгаалах зорилго бүхий ОУБ буй болсон. Хэдийгээр Үндэстнүүдийн Холбооны дүрэм дайн хийхийг хориглоогүй боловч түүнийг хязгаарлаж, хязгаарлалтыг зөрчсөн улсын эсрэг арга хэмжээ авах боломжийн тухай заасан болно.

1928 онд Брайан – Келлогийн Пакт олон улсын эрх зүйд чухал ач холбогдол бүхий үйл явдал болсон. Энэ бол улс гүрнүүд маргаантай асуудлаа эв зүйгээр зохицуулж хоорондын харилцаандаа дайны арга хэрэглэхээс татгалзах үзэл баримтлалыг тусгасан анхны олон талт гэрээ юм.

Дэлхийн II дайны төгсгөлд НҮБ байгуулагдсанаар олон улсын эрх зүйн хөгжилд шинэ үе нээгдэв. НҮБ-ын дүрэм олон улсын эрх зүйн уламжлалт ардчилсан зарчмуудыг бататгасан төдийгүй дэвшилт шинэ зарчмуудыг тунхагласан. Ийм учраас одоогийн мөрдөж байгаа олон улсын эрх зүйг ХХ зууных гэж нэрлэдэг.

Дэлхийн I ба II дайны дараа олон улсын харилцаанд гарсан өөрчлөлт ОУЭЗ-н цаашдын хөгжилд зохих нөлөө үзүүлж, түүний өрөөсгөл, хэвийн биш байдлыг засаж залруулахад тус дөхөм болсон. Энэ хугацаанд ОУЭЗ-н субъектийн бүрэлдэхүүнд тооны төдийгүй чанарын өөрчлөлт гарлаа. Колонийн систем задарсны үр дүнд гарч ирсэн тусгаар тогтносон орнууд олон улсын харилцаанд идэвхтэй оролцож олон улсын эрх зүйг ардчилсан ёсоор гүнзгий өөрчлөх үйлст жинтэй хувь нэмэр оруулж байна. Улс хоорондын байгууллага олшрон хөгжиж ОУЭЗ-н нөлөөтэй субъект болов. Тэдгээр нь орчин үеийн өвч хамааралтай асуудлаар хүн төрлөхтний хамтын ажиллагааны зарчим, хэм хэмжээг боловсруулан хэрэгжүүлэхэд үнэтэй тус дэмжлэг үзүүлж байна.

ХХ зууны үндсэн агуулга нь капиталист болон социалист орнуудын тэмцэл хийгээд хамтын ажиллагаа байсан юм. Дэлхийн II дайны дараа колонийн тогтолцооны задралын үр дүнд дэлхийн улс орнуудын 2/3 нь

“гурав дахь ертөнц” гэгчид хамаарч байлаа. Эдгээр хөгжиж буй орнууд аливаа нийгэм, эдийн засгийн тогтолцоог тууштай баримтлаагүй ч хоёр системийн орнуудын харилцааг засан залруулж олон улсын эрх зүйн дэвшилт хөгжилд эергээр нөлөөлсөн.

80-90-ээд оны зааг дээр Дорнод Европын орнуудын хувьсгал, БНАГУ болон ХБНГУ-ын нэгдэл, Хятад, Вьетнам, Монголын нийгэм, эдийн засгийн шинэчлэн өөрчлөлт, ЗСБНХУ үгүй болсон нь дэлхийн социалист системийн задралд хүргэсэн. Дэлхийд буй болсон нийгэм, эдийн засаг, эрх зүйн шинэ нөхцөл байдал нь ОУЭЗ-г өөрчлөн шинэчлэхийг шаардаж байна. Энэ асуултанд гурав дахь мянган хариулт өгнө.

Ашигласан ном, зохиол

1. Большая юридическая энциклопедия, М.1996
2. Англи-монгол-орос хууль зүйн толь С.Нарангэрэл УБ.,1994
3. Международное право М.1970.Под ред. В.М.Лужковского
4. Международное право М.1999.Под ред.Ю.М. Колосова
5. Международное право М.2000.Под ред.Ю.М. Колосова
6. Международное право М.1977.Под ред. Яна Броунли
7. Международное публичное право М.1998 Под ред. К.Я.Бекяшева
8. Олон улсын эрх зүй УБ. 1999 Ред. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр
9. Contemporary International Relations Chapter 17, London 1988 edited by Daniel S.Papp
10. An Introduction to International Law Toronto, Canada, 1988 Mark W.Danis
11. Contemporary International Law, second edition 1991 Werner Levi Colorado, USA

The article deals with comparative study of concepts put forward by lawyers M. Foshell, N.A. Bekeshev, U.M. Kolosov, G.S. Starodubtsev, W.Levi on chronology of international law. It is proposed to follow chronology concept of G.S. Starodubtsev, research fellow of Moscow Law Academy for his comprehensive approach.